



## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 05 сарын 22 өдөр

Дугаар 25

Улаанбаатар хот

### Гишүүнээр элсүүлэх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, “Монголын хөрөнгийн бирж” хувьцаат компанийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.20, Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын гишүүнчлэлийн журмын 3 дугаар зүйлийн 3.2.1 дэх заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 05 дугаар сарын 22-ний өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Мандал Капитал Маркетс ҮЦК” ХХК-ийг “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн гишүүнээр элсүүлсүгэй.
2. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын гишүүнчлэлийн журмын дагуу “Мандал Капитал Маркетс ҮЦК” ХХК-тай “Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын гишүүнчлэлийн гэрээ” байгуулахыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Цогтбаяр)-д даалгасугай.
3. Холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журам, зааврыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж ажиллахыг “Мандал Капитал Маркетс ҮЦК” ХХК (А.Өлзийдэлгэр)-д үүрэг болгосугай.
4. Уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалах брокерын бэк оффис (back office)-ын системийн хөгжүүлэлт болон арилжаа эрхлэгч байгууллагын системтэй шаардлагатай холболтыг бүрэн хийж 2024 оны 09 сарын 30-ны өдрөөс өмнө дуусгахыг “Мандал Капитал Маркетс ҮЦК” ХХК (А.Өлзийдэлгэр)-д даалгасугай.
5. Хууль тогтоомж болон зах зээлд мөрдөгдөж буй журам, заавар, гишүүнчлэлийн гэрээгээр хүлээсэн гишүүн компанийн үүргийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Цогтбаяр)-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ТОГТОХБАЯР

1594010061



## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 05 сарын 22 өдөр

Дугаар 26

Улаанбаатар хот

### Хөрөнгө дахин үнэлэх тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7 дугаар зүйлийн 7.1, “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.19, 5.7.27 дахь заалтууд, компанийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас өгсөн зөвлөмж, байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлт, Захирлын зөвлөлийн хурлын шийдвэр, Аудитын хорооны хурлын дүгнэлт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн санхүүгийн тайланд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч одоогийн байдлаар ашиглаж байгаа, цаашид ашиглах боломжтой, хавсралтад дурдсан нийт 28 нэр төрлийн нийт 4,742,743.49 /дөрвөн сая долоон зуун дөчин хоёр мянга долоон зуун дөчин гурван төгрөг дөчин есөн мөнгө/ төгрөгийн балансын анхны үнэ бүхий хөрөнгийг дахин үнэлэхийг дэмжиж, холбогдох хууль, дүрэм, журмын дагуу Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хандан зохих зөвшөөрөл, шийдвэрийг авч, хөрөнгийг дахин үнэлэх ажлыг зохион байгуулахыг компанийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Цогтбаяр)-д даалгасугай.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо (Н.Улаанхүү)-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ТОГТОХБАЯР

1524010058



## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 05 сарын 22 өдөр

Дугаар 27

Улаанбаатар хот

### Хөрөнгө актлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, 31.3, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6 дугаар зүйлийн 6.1, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 268 дугаар “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоол, “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.19, 5.7.27 дахь заалтууд, Өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлт, Захирлын зөвлөлийн хурлын шийдвэр, Аудитын хорооны хурлын дүгнэлт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн санхүүгийн тайланд бүртгэлтэй, элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь бүрэн нөхсөн, засаж сэлбэн ашиглах боломжгүй болсон, хавсралт 1-д дурдсан нийт 8 нэр төрлийн 239,365,363.66 (хоёр зуун гучин есөн сая гурван зуун жаран таван мянга гурван зуун жаран гурван төгрөг жаран зургаан мөнгө) төгрөгийн балансын анхны үнэ бүхий биет бус хөрөнгө, хавсралт 2-д дурдсан 7 нэр төрлийн 624,844.62 (зургаан зуун хорин дөрөв мянга найман зуун дөчин дөрвөн төгрөг жаран хоёр мөнгө) төгрөгийн балансын анхны үнэ бүхий тавилга, эд хогшил, хавсралт 3-д дурдсан 7 нэр төрлийн 5,607,202.26 (таван сая зургаан зуун долоон мянга хоёр зуун хоёр төгрөг хорин зургаан мөнгө) төгрөгийн балансын анхны үнэ бүхий машин, тоног төхөөрөмж, хавсралт 4-д дурдсан 18 нэр төрлийн 1,150,636.36 (нэг сая нэг зуун тавин мянга зургаан зуун гучин зургаан төгрөг гучин зургаан мөнгө) төгрөгийн балансын анхны үнэ бүхий бага үнэтэй, түргэн элэгдэх зүйл болон материалыг тус тус актлахыг дэмжиж, холбогдох хууль, журмын дагуу Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хандан шийдвэрлүүлж, хөрөнгө актлах ажлыг зохион байгуулахыг компанийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Цогтбаяр)-д даалгасугай.
2. Компанийн санхүүгийн тайланд үлдэгдэл өртөгтэй ч эвдэрч гэмтсэн, ашиглах тохиолдолд их хэмжээний засвар, үйлчилгээ шаардлагатай, засвар үйлчилгээ хийгдсэн ч эдийн засгийн хувьд үр ашиггүй гэж үзсэн хавсралт 5-д дурдсан 1 нэр төрлийн 5,512,500.04 (таван сая таван зуун арван хоёр мянга таван зуун төгрөг дөрвөн мөнгө) төгрөгийн балансын үлдэгдэл өртөгтэй тээврийн хэрэгслийг актлан дуудлага худалдаагаар борлуулахыг дэмжиж, холбогдох хууль, журмын дагуу Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хандан шийдвэрлүүлж, хөрөнгө актлах, дуудлага худалдаагаар борлуулах ажлыг

+1524010057

зохион байгуулахыг компанийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Цогтбаяр)-д даалгасугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо (Н.Улаанхүү)-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ТОГТОХБАЯР



## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 05 сарын 22 өдөр

Дугаар 28

Улаанбаатар хот

### Компанийн 2024 оны санхүүгийн төлөвлөгөөнд тодотгол хийх тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйл, "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.1, 5.7.27 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журмын 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалт, Аудитын хорооны 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн ... дугаар дүгнэлт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн 2024 оны орлого, зарлагын төлөвлөгөөний тодотголыг энэхүү тогтоолын Нэгдүгээр хавсралтаар, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний тодотголыг Хоёрдугаар хавсралтаар, Татан төвлөрүүлсэн хөрөнгөөс 2024 онд санхүүжүүлэх зарцуулалтын төлөвлөгөөний тодотголыг Гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Компанийн үйл ажиллагааны зардлыг боломжит хэмжээгээр хэмнэж ажиллахыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Цогтбаяр)-д үүрэг болгосугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо (Н.Улаанхүү)-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ТОГТОХБАЯР

•1524010054

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХК-ИЙН 2024 ОНЫ ОРЛОГО, ЗАРДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
ТОДОТГОЛЫН САНАЛ

/мян төг/

#	Үзүүлэлт	2023 оны гүйцэтгэл	2024 он				
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл 2024/03/31	ХБГ 2024/12/31	Тодотгол +/- 2024/12/31	Тодотгосон дүн
<b>I (А+Б)</b>	<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>16,722,642</b>	<b>17,778,554</b>	<b>10,167,754</b>	<b>37,076,055</b>	<b>19,297,501</b>	<b>37,076,055</b>
<b>A</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО</b>	<b>12,160,202</b>	<b>11,528,554</b>	<b>3,755,560</b>	<b>13,061,719</b>	<b>1,533,165</b>	<b>37,076,055</b>
1	Хувьцааны арилжааны шимтгэл	2,464,642	2,422,216	749,756	2,422,216	-	2,422,216
2	Бондын арилжааны шимтгэл	91,084	615,864	6,150	615,864	-	615,864
3	ХОС-ын нэгж эрх арилжааны шимтгэл	42,745	109,239	755	109,239	-	109,239
4	Нүүрсний арилжааны шимтгэл	6,678,705	5,865,848	2,098,345	7,399,013	1,533,165	7,399,013
5	Төмөр жоншны арилжааны шимтгэл	176,517	501,626	163,549	501,626	-	501,626
6	Зэс арилжааны шимтгэл		153,711		153,711	-	153,711
7	Гишүүнчлэлийн жилийн хураамж	109,282	80,940	42,934	80,940	-	80,940
8	Терминал ашигласны хураамж	63,411	72,540	15,600	72,540	-	72,540
9	Үнэт цаас бүртгэх үйлчилгээний орлого	1,861,853	424,400	117,577	424,400	-	424,400
10	УУБ бүртгэх үйлчилгээний хөлс		390,621	100,818	390,621	-	390,621
11	Бүртгэлтэй компанийн жилийн хураамж	391,385	517,294	382,247	517,294	-	517,294
12	Сургалтын орлого	8,182	43,200	6,873	43,200	-	43,200
13	Мэдээллийн үйлчилгээний орлого	163,919	250,857	52,132	250,857	-	250,857
14	Бусад орлого	108,479	80,200	18,825	80,200	-	80,200
<b>B</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО</b>	<b>4,562,440</b>	<b>6,250,000</b>	<b>6,412,194</b>	<b>24,014,336</b>	<b>17,764,336</b>	<b>24,014,336</b>
1	Хүүгийн орлого	4,562,440	6,250,000	6,412,194	24,014,336	17,764,336	24,014,336
<b>B</b>	<b>НИЙТ ЗАРДАЛ</b>	<b>6,198,409</b>	<b>9,428,971</b>	<b>1,831,165</b>	<b>9,840,413</b>	<b>411,442</b>	<b>9,840,413</b>
1	Ажилтнуудын цалин хөлс	2,058,917	3,457,573	702,152	3,457,573	-	3,457,573
2	НДШ-ийн зардал	256,963	466,772	87,718	466,772	-	466,772
3	Удирдлагын зардал	152,809	371,775	53,839	442,354	70,579	442,354
4	Материал, бичиг хэрэг	31,779	46,872	6,433	46,872	-	46,872
5	Харилцаа холбооны зардал	7,709	11,216	2,332	11,216	-	11,216
6	Интернет ашиглалт	15,484	18,641	3,494	18,641	-	18,641
7	Программ хангамж ашиглалтын зардал	-	15,840	-	15,840	-	15,840
8	Шатахуун, тээврийн хэрэгслийн зардал	1,213	11,258	-	11,258	-	11,258
9	Цахилгаан үүсгүүр цэнэглэлт	492	-	-	-	-	-
10	Урсгал засвар	23,510	54,513	222	54,513	-	54,513
11	Цахилгаан, дулаан, ус, хог	54,907	59,589	16,051	74,523	14,934	74,523
12	Албан томилолт	35,086	80,294	7,023	254,276	173,982	254,276
13	Сургалт семинар	28,525	171,492	11,203	201,650	30,158	201,650
14	Ажилтнуудын нийгэм, соёлын зардал	4,465	144,230	15,467	144,230	-	144,230
15	ЗЗ идэвхжүүлэлт, бизнес харилцааны зардал	47,300	199,000	4,402	199,000	-	199,000
16	ХЭХ зохион байгуулалтын зардал	37,760	60,000	455	60,000	-	60,000
17	Мэдээлэл технологийн зардал	111,367	113,451	29,537	113,451	-	113,451
18	Мэдээллийн үйлчилгээний зардал				53,985	53,985	53,985

19	Бусад зардал	74,675	82,719	10,325	122,719	40,000	122,719
20	ҮХХ-ийн татвар		29,550	-	29,550	-	29,550
21	Элэгдлийн зардал	609,066	900,532	162,196	900,532	-	900,532
22	Зохицуулах үйлчилгээний хөлс	704,567	966,850	297,089	1,120,167	153,316	1,120,167
23	Систем ашиглалтын зардал:	1,703,813	1,853,017	421,228	1,853,017	-	1,853,017
	Үүнд: Системийн элэгдлийн зардал	684,336	684,336	171,084	684,336	-	684,336
	Системийн үйлчилгээний зардал	1,019,477	1,168,682	250,144	1,168,682	-	1,168,682
24	Зөвлөх үйлчилгээний зардал	238,000	136,000	-	136,000	-	136,000
25	Болзошгүй зардал	-	177,786	-	52,273	(125,513)	52,273
<b>Г</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ АЛДАГДАЛ (А+Б)-В</b>	<b>10,524,234</b>	<b>8,349,583</b>	<b>8,336,589</b>	<b>27,235,642</b>		<b>27,235,642</b>
Д	Гадаад валютын ханшийн бодит бус цэвэр орлого	(186,717)		(204,417)	(204,417)		(204,417)
<b>Е</b>	<b>ТАТВАРЫН ӨМНӨХ ЦЭВЭР АШИГ (Г+Д)</b>	<b>10,337,516</b>	<b>8,349,583</b>	<b>8,132,171</b>	<b>27,031,225</b>		<b>27,031,225</b>
	Хүүгийн орлогын татвар	371,632	-				
	<b>Татварын дараах цэвэр ашиг</b>		<b>7,523,047</b>	<b>7,317,551</b>	<b>24,328,102</b>		<b>24,328,102</b>

2024 ОНД КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГООС САНХҮҮЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
ТОДОТГОЛЫН

№	Бараа, ажил үйлчилгээний нэрс	Тоо хэмжээ	Дүн	Нэмэгдэх (+)		Хасагдах (-)		Тодотгосон төлөвлөгөө	
				Тоо хэмжээ	Дүн	Тоо хэмжээ	Дүн	Тоо хэмжээ	Дүн
<b>Нэг. Тээврийн хэрэгсэл</b>									
1	Ажилтнуудын автобус	1	161,100,000					1	161,100,000
	<b>Дүн I</b>	<b>1</b>	<b>161,100,000</b>	-	-	-	-	<b>1</b>	<b>161,100,000</b>
<b>Хоёр.Тавилга эд хогшил</b>									
1	Бичиг хэргийн цоожтой шакаф	1	16,910,600					1	16,910,600
2	Оффис сандал	15	7,648,500					15	7,648,500
3	Оффис ширээ /цоожтой шүүгээ хаалттай/	24	21,021,600					24	21,021,600
4	Түшлэгтэй, зөвлөвчтэй урт сандал	1	1,000,000					1	1,000,000
5	Сейф	2	1,699,800					2	1,699,800
6	Үзүүлэнгийн тавиур	1	2,500,000					1	2,500,000
7	Хувцасны шакаф	72	21,600,000					72	21,600,000
8	Самбар /ханад өлгөдөг/	2	726,000					2	726,000
9	Тумбочка	6	2,159,400					6	2,159,400
10	Хувцасны өлгүүр	2	1,696,000					2	1,696,000
11	Архивын нягтруулсан шүүгээ	2	13,104,900					2	13,104,900
12	Архивын тавцант тавиур	3	3,750,000					3	3,750,000
13	Тавцант гар ачааны тэрэг /хөрөнгө зөөх/	1	1,000,000					1	1,000,000
14	Тавцант түрдэг тэрдэг /баримт зөөх/	1	390,000					1	390,000
	<b>Дүн II</b>	<b>133</b>	<b>95,206,800</b>	-	-	-	-	<b>133</b>	<b>95,206,800</b>
<b>Гурав.Тоног төхөөрөмж</b>									
1	Сканнер	2	6,999,800					2	6,999,800
2	Зөөврийн компьютер	12	49,020,000					12	49,020,000
3	Air condition	1	2,680,000					1	2,680,000
4	Агаар цэвэршүүлэгч, чийгшүүлэгч	5	3,495,000					5	3,495,000
5	Суурин компьютер i5 /Дэлгэц 27 инч/	8	27,824,576					8	27,824,576
6	Суурин компьютер i7 /Дэлгэц 27 инч/	2	8,437,600					2	8,437,600
7	Дэлгэц 27 инч	12	8,638,800					12	8,638,800
8	Принтер	5	11,149,500					5	11,149,500
9	Өнгөт принтер	3	6,299,700					3	6,299,700
10	Ухаалаг самбар	3	31,800,000					3	31,800,000
11	Macbook PRO	1	7,999,900					1	7,999,900
12	Зөөврийн таблет	2	11,800,000	7	41,300,000			9	53,100,000
13	Утасны аппарат	3	554,400					3	554,400
14	Халаагуур тень	2	858,000					2	858,000
15	Архивын баримт үдэгч машин	2	914,400					2	914,400
16	Тог баригч	1	399,900					1	399,900
17	Цаас устгагч	2	1,598,000					2	1,598,000
18	Кофе чанагч	1	4,499,900					1	4,499,900
19	Ус буцалгагч	1	489,900					1	489,900
20	Цахилгаан дрилл /цохилтгой/	1	250,000					1	250,000
21	Суурин компьютер (хяналтын)	1	7,500,000					1	7,500,000
22	Дэлгэц (хяналтын)	2	1,483,800					2	1,483,800
23	Свит (PoE)	8	7,405,600					8	7,405,600
24	Свич(unmanaged)	8	2,040,000					8	2,040,000
25	Свич(managed)	8	7,439,200					8	7,439,200
26	Тог баригч (Smart UPS)	8	5,599,200					8	5,599,200
27	Сервер	2	48,313,200					2	48,313,200
28	Дэлгэц (суурь хөлийн хамт )	2	1,650,000					2	1,650,000
29	Хөргөгч	3	1,800,000					3	1,800,000
30	Wifi төхөөрөмж (router)			3	1,260,000			3	1,260,000
	<b>Дүн III</b>	<b>111</b>	<b>268,940,376</b>	<b>10</b>	<b>42,560,000</b>	-	-	<b>121</b>	<b>311,500,376</b>
<b>Дөрөв. Биет бус хөрөнгө /програм хангамж, лиценз/</b>									
1	Adobe - Creative cloud yearly subscription	1	3,776,500					1	3,776,500
2	Oracle 19C Database Enterprise Edition (2 Core, CPU based licensing) with Standard Premier Support								
3	Oracle Real Application Clusters-Processor Perpetual with Standard Premier Support	1	112,475,790					1	112,475,790
4	Oracle WebLogic Suite-Processor Perpetual with Standard Premier Support								
5	Oracle Linux OS with Standard Premier Support	3	26,865,930					3	26,865,930
6	Red Hat Enterprise Linux Server, Premium support with High Availability Add-On, Resilient Storage Add-on	3	29,321,552					3	29,321,552



7	Red Hat Enterprise Linux Server, Premium support with High Availability Add-On, Resilient Storage Add-on	2	19,547,700					2	19,547,700
8	Oracle Linux OS with Standard Premier Support	1	8,955,310					1	8,955,310
9	Oracle 19C Enterprise DB Edition (2 Core, CPU based licensing) with Standard Premier Support	1	29,949,800					1	29,949,800
10	Red Hat Enterprise Linux Server, Premium support with High Availability Add-On, Resilient Storage Add-on	3	29,321,552					3	29,321,552
11	Oracle Linux OS with Standard Premier Support	1	8,955,310					1	8,955,310
12	Oracle Database Standard Edition (Socket ba	1	27,549,000					1	27,549,000
13	Fortinet license	2	22,500,000			2	22,500,000		
14	Microsoft office 365	1	91,198,800					1	91,198,800
<b>Дүн IV</b>		<b>20</b>	<b>410,417,244</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>22,500,000</b>	<b>18</b>	<b>387,917,244</b>
<b>Тав. Барилга байгууламжийн засвар үйлчилгээ</b>									
1	Барилгын гадна фасад засвар	1	175,000,000					1	175,000,000
<b>Дүн V</b>		<b>1</b>	<b>175,000,000</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>175,000,000</b>
<b>НИЙТ ТОО</b>		<b>266</b>	<b>1,110,664,420</b>	<b>10</b>	<b>42,560,000</b>	<b>2</b>	<b>22,500,000</b>	<b>274</b>	<b>1,130,724,420</b>

ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН 2024 ОНЫ ЗАРЦУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
ТОДОТГОЛ

/мянган төгрөг/

№	Бараа, ажил үйлчилгээний нэрс	Тоо хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл 2024.04.30	Нэмэгдэх (+)		Хасагдах (-)		Тодотгосон төлөвлөгөө		
					Тоо хэмжээ	Үнийн дүн	Тоо хэмжээ	Үнийн дүн	Тоо хэмжээ	Үнийн дүн	
<b>Нэг. Арилжааны системийн сайжруулалт</b>											
1	MIT арилжааны болон хяналтын программ хангамжийн шинэчлэл	5	1,383,742.5						5	1,383,742.50	
	Үүнээс:										
1.1	Нөөц төвийн тоног төхөөрөмжийн шинэчлэлт, системийн тохиргоо	1	209,569.80						1	209,569.80	
1.2	CSD системийн өгөгдлийн санд хийгдэх ажил	1	27,542.80						1	27,542.80	
1.3	MIT систем дээр хийгдэх нэмэлт өөрчлөлт	1	109,051.30						1	109,051.30	
1.4	Таваарын арилжааны системийн нэмэлт сайжруулалт	1	100,000.00						1	100,000.00	
1.5	MIT арилжааны болон хяналтын программ хангамжийг шинэчлэх ажил	1	937,578.60						1	937,578.60	
2	MIT үйлдлийн системийн шинэчлэл /license upgrade/	1	151,487.90						1	151,487.90	
3	MIT системийн жилийн үйлчилгээний зардал	1	1,059,543.40				1	1,059,543.40		-	
4	MIT-ийн түүхий эд болон деривативын арилжааны модуль	1	404,405.90						1	404,405.90	
	<b>Дүн I</b>	<b>8</b>	<b>2,999,179.70</b>	-	-	-	-	<b>1</b>	<b>1,059,543.40</b>	<b>7</b>	<b>1,939,636.30</b>
<b>Хоёр. Мэдээлэл технологийн аюулгүй байдал</b>											
5	Серверийн өрөөний өргөтгөл, шинэчлэл, стандартжуулалт	1	1,026,000.00						1	1,026,000.00	
6	Сүлжээний тоног төхөөрөмж шинэчлэх	1	176,743.70						1	176,743.70	
	<b>Дүн II</b>	<b>2</b>	<b>1,202,743.70</b>	-	-	-	-	-	<b>2</b>	<b>1,202,743.70</b>	
<b>Гурав. Дотоод үйл ажиллагааны цахимжуулалт</b>											
7	Хүний нөөц, бичиг хэргийн программ	1	48,400.00	1	38,530.01				1	48,400.00	
	<b>Дүн III</b>	<b>1</b>	<b>48,400.00</b>	<b>1</b>	<b>38,530.01</b>	-	-	-	<b>1</b>	<b>48,400.00</b>	
<b>Дөрөв. Хөрөнгийн зах зээлийн сургалт үйлчилгээ, мэдээллийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх төв бий болгох зорилгоор барилга байгууламжийн дотоод зохион байгуулалтын өөрчлөлтөд оруулах хөрөнгө оруулалт</b>											
8	Хөрөнгийн зах зээлийн сургалт үйлчилгээ, мэдээллийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх төв бий болгох зорилгоор барилга байгууламжийн дотоод зохион байгуулалт	1	2,244,155.85	1	2,103,184.98				1	2,244,155.85	
	<b>Дүн IV</b>	<b>1</b>	<b>2,244,155.85</b>	<b>1</b>	<b>2,103,184.98</b>				<b>1</b>	<b>2,244,155.85</b>	
<b>ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГӨ ЗАРЦУУЛАХ ДҮН</b>		<b>12</b>	<b>6,494,479.25</b>	<b>2</b>	<b>2,141,714.99</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>1,059,543.40</b>	<b>11</b>	<b>5,434,935.85</b>